ДУНДГОВЬ АЙМАГ
ЛУУС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТОГТООЛ

2017 оны 11 сарын 22 өдөр Дугаар 17 Цагаан-Овоо

Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах тов зарлах тухай

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийн зээл олголтын 20-оос доошгүй хувь нь бүрдэж, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах 5 төслийн санал ирснийг шалгаруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.11 дэх заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулах товыг 2017 оны 11 сарын 30-ны өдөр зохион байгуулахаар тогтсугай.

2.Сонгон шалгаруулалтыг хууль журмын дагуу нээлттэй зарлан зохион байгуулж ажиллахыг сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөлийн дарга Л.Цогзолмаа –д үүрэг болгосугай.

ДАРГА Д.ЭНХБААТАР

**ДУНДГОВЬ АЙМАГ**
**ЛУУС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2017 оны 11 сарын 22 өдөр Дугаар 28 Цагаан-Овоо

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25. 4 дэх заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөгчдийн Хурлаас батлагдсан тогтоолуудыг хүчингүй болгож хавсралтаар баталсугай.

2. Цаашид Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн бүрдүүлсэн материал, хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхийг ИТХ-ын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА Д.ЭНХБААТАР

040013

Сумын ИТХ-ын 2017 оны
11 сарын 22-ны өдрийн 18 дугаар
тогтоолын хавсралт

Хүчингүй болгосон тогтоолын жагсаалт

| д/д | Шийдвэрийн агууллага | Батлагдсан он сар өдөр | Тогтоолын дугаар |
|---|---|---|---|
| 1 | Нохой эзэмших журам | 2009. 04 .30-ны өдрийн хуралдаанаар баталсан | |
| 2 | Журам батлах тухай | 2009. 10. 12 | 27 |
| 3 | Гадны аймаг сумын малчдад төлбөр тогтоох журам | 2011. 06 . 28 | №30 |
| 4 | Төвийн худаг ажиллуулах журам, усны үнэ тогтоох тухай | 2014.12.04. | 43 |
| 4 | Төлбөр тогтоох тухай | 2016.06.10 | №18 |
| 5 | Үйлчилгээний хураамж тогтоох тухай | 2016.06.10 | №19 |
| 6 | Хог хаягдал гаргасны төлбөр, хураамж тогтоох тухай | 2016.06.10 | №20 |
| 7 | Үйлчилгээний үнэ тариф тогтоох тухай | 2016.06.10 | №21 |

/Togtool 2017/ doc

ДУНДГОВЬ АЙМАГ
## ЛУУС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 22 өдөр　　Дугаар 19　　Цагаан-Овоо

2017 оны тодотгосон төсөв батлах тухай

Монгол Улсын , Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "б" төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

**1.** Сумын 2017 оны төсөвт төвлөрүүлэх орлогын нэр төрөл, хэмжээг дор дурдсанаар баталсугай:

| д/д | | Байгууллага, орлогын нэр төрөл | ДҮН /мянган төгрөг/ |
|---|---|---|---|
| **1.1.** | | **Сум (дүүрэг)-ын төсвийн татварын орлого** | **22592,5** |
| | 1.1.1. | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар | 13000.0 |
| | 1.1.2. | бууны албан татвар | 1140.0 |
| | 1.1.3. | улсын тэмдэгтийн хураамж | 1950,0 |
| | 1.1.4. | агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж | |
| | 1.1.5. | Хөрөнгийн орлого | 4871,0 |
| | 1.1.6. | ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр | |
| | 1.1.7. | түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | |
| | 1.1.8. | хүн амын хэрэглээний зориулалтаар ус, рашаан ашигласны | |
| | 1.1.9. | орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан | |
| | 1.1.10. | нохойны албан татвар | |
| | 1.1.11. | хог хаягдлын үйлчилгээний хураамж | 1631,5 |
| | 1.1.12. | хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад | |
| **1.2.** | | **Сум (дүүрэг)-ын төсвийн татварын бус орлого** | **6754,6** |
| | 1.2.1. | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 3838,0 |
| | 1.2.2. | Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого | 2344,6 |
| | 1.2.3. | хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад | 572,0 |

| | **Нийт дүн** | **29347,1** |
|---|---|---|

**2.** Сумын 2017 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурьдсанаар батлаcугай:

| д/д | ТЕЗ, түүний харьяа байгууллага | ДҮН /мянган төгрөг/ |
|---|---|---|
| 2.1. | **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга** | |
| 2.2. | **Засаг дарга**<br><br>Үүнээс: Төсвийн байгууллагын өөрийн орлого<br>Соёлын төв<br>Сургууль | **2406,0**<br><br>**2300,0**<br>**106.0** |

**3.** Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 78889,6 мянган төгрөгөөр баталсугай.

4. Сумын 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

| д/д | | Төсвийн захирагч | ДҮН /мянган төгрөг/ |
|---|---|---|---|
| **3.1.** | | **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга**<br>Урсгал зардал<br>Хөрөнгийн зардал | 34704,3 |
| | 3.1.1. | Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга<br>Урсгал зардал, үүнээс:<br>арга хэмжээ 1<br>арга хэмжээ 2 | 34704,3 |
| **3.2.** | | **Засаг дарга**<br><br>Урсгал зардал<br>Хөрөнгийн зардал | **299594,4**<br>217173,6<br>82420,8 |
| | 3.2.1. | Засаг даргын тамгын газар<br><br>Урсгал зардал, үүнээс | **213353,5**<br>213353,5 |
| | 3.2.2. | Засаг даргын шууд харьяаны байгууллага 1<br>Урсгал зардал, үүнээс: | **3820,1**<br>3820,1 |

**5.** Сумын төсвөөс 2017 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг 1115809,0 мянган төгрөгөөр баталсугай.

**6.** Сумын төсвөөс 2017 оны төсвийн жилд төсвийн шууд захирагчдад олгох Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

| Д/д | Сум (дүүрэг)-ын нэр | СӨБ | ЕБС | Соёлын үйлчилгээ | Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Луус сум | 146695,4 | 348965,9 | 47808,8 | 238040,2 | 781510,3 |
| **НИЙТ ДҮН** | | **146695,4** | **348965,9** | **47808,8** | **238040,2** | **781510,3** |

**7.** Сумын 2017 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай:

1. Сумын татварын болон татварын бус орлого 25509,1 мянган төгрөг;
2. Сум ын төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 222530,8 мянган төгрөг;
3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 48359,6 мянган төгрөг
4. Сумын төсөвт аймгийн төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг 779104,3 мянган төгрөг

**9.** "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт"-ийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

**10.** Орон нутгийн хөгжлийн сангаар 2017 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

**11.**Сумын 2017 оны тусгай сангуудын орлого зарлага санхүүжилтийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

**12** .Батлагдсан төсвийг МУ-ын төсвийн хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулж орон нутгийн орлогыг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллахыг Сумын төсвийн ерөнхийлөн захирагч Засаг дарга /Л. Цогзолмаа/-д үүрэг болгосугай

ДАРГА Д. ЭНХБААТАР

ИТХ-ын 2017 оны 11 сарын 22-ны өдрийн
12 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Луус сумын ИТХ-ын 2017 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэх
хөтөлбөр, хүрэх үр дүн

1. **Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:**

/мянган төгрөгөөр/

| д/д | ТЕЗ, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт | 2017 оны зорилтот түвшин |
|---|---|---|
| 1 | **1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** | |
| 1.1. | Бүх төрлийн даатгалд хамруулан цалин хөлсийг цаг хугацаанд нь олгоно. Үр дүнгийн гэрээгээ хүлээсэн үүргийн биелэлтийг тооцож, журмын дагуу урамшуулал олгох | 30951,9 |
| 1.2. | ИТХ-ын тасралтгүй үйл ажиллагааг хангах, төлөвлөсөн ажлууд болон бусад цаг үеийн орон нутгийн тулгамдсан болон бусад асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмгдүүлэх, хэлэлцүүлэг ярилцлага зохион байгуулах үйл ажиллагааг сайжруулна. | 1683,9 |
| 1.3. | МУ-ын ЗЗНДНТУ-ын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан ИТХ-ын чиг үүргийг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэн ажиллана. | 771,5 |
| 1.4. | Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ | |
| 1.5. | ИТХ-ын төлөөлөгчид болон тэргүүлэгчдэд хууль эрх зүйн мэдлэг олгох, мэдээ мэдээллээр хангах, дотоодын сургалт зохион байгуулана. | 270,0 |
| 1.6. | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 1027,0 |
| **1.7.** | **нийт зардал** | **34704,3** |
| **2** | **ЗДТГ** | |
| 2.1. | Засаг даргын тамгын газрын үндсэн үйл ажиллагаа | |
| 2.2. | Байгууллагын албан хаагчид болон гэрээт ажилчид иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлсний цалин нэмэгдэл, урамшуулал, даатгал олгох | 133091.6 |
| 2.3. | Албан хаагчдын ажлын байрны ажиллах боломж, иргэдэд хүрч үйлчлэх нөхцлийг хангах, /Цахилгаан, дулаан, ус, шатахуун, бичиг хэрэг, шуудан холбоо/ | 21621.7 |
| 2.4. | Байгууллагын ажилтнуудыг семинар сургалтад явуулж сургаж дадлагажуулна мөн удирдлагууд албан хаагчид аймаг хотод ажил хөөцөлдөх | 3702.5 |
| 2.5. | Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор эд хогшил тоног төхөөремж авах, засвар хийх | 3346.8 |
| 2.6. | Дотоод сургалт, хурал зөвлөгөөн явуулах, иргэдийг сургалт мэдээллээр хангах | 650.0 |
| 2.7. | Үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгслийн болон бусад татвар, төлбөрийг хугацаанд нь төлж, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийлгэнэ | 1300.6 |

| | | |
|---|---|---|
| 2.8. | Орон нутгийн нөөц хөрөнгө | 3820.1 |
| 2.9. | Биеийн тамирын уралдаан тэмцээний зардал | 368.7 |
| 2.10. | сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн | 8314.2 |
| 2.11. | тэтгэвэрт гарсны тэтгэмж | 6750.1 |
| 2.12. | нэг  удаагийн тэтгэмж урамшуулал | 6780.0 |
| **2.13** | **Нийт зардал** | **189746.3** |
| **3.** | **Баг** | |
| 3.1. | БЗД нарын  иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлсний цалин нэмэгдэл, урамшуулал, даатгалыг бүрэн олгох | 26041.3 |
| 3.2. | БЗД нарын ажлын байрны ажиллах боломж, иргэдэд хүрч үйлчлэх нөхцлийг хангах, /Цахилгаан, дулаан,томилолт ус, шатахуун, бичиг хэрэг, шуудан холбоо г.м/ | 174.0 |
| 3.3. | Байгууллагын ажилтнуудыг семинар сургалтад явуулж сургаж дадлагажуулна мөн удирдлагууд албан хаагчид аймаг хотод ажил хөөцөлдөх | 1066.0 |
| 3.4. | БЗД нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх | 0.0 |
| 3.5 | БЗД нарын ажлыг хэвийн явуулах зорилгоор эд хогшил тоног төхөөрөмж авах, засвар хийх, татвар төлөх | 146.0 |
| **3.6** | **Нийт зардал** | **27427.3** |
| **4.** | **ЭМТ** | |
| 4.1. | Эмч, ажилчдын цалин болон нийгмийн,эрүүл мэндийн бүхий л даатгалд хамруулж,цалинг цаг тухайд нь олгож ажиллана. | 175526.3 |
| 4.2. | Эмч, ажилчдын ур чадварыг сайжруулж ажлын үр бүтээлтэй хэлбэрийг нэвтрүүлж үр дүнг тооцно. | 12752.6 |
| 4.3. | Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор ажиллах орчинг бүрдүүлж дулаанаар хангаж,түргэн тусламжийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх. | 15044.6 |
| 4.4. | Хэвтэн эмчлүүлэгчдийг эмчилгээнд тохирсон хоол хүнс хүнсээр хангаж,эмийн зохистой хэрэглээг эмчилгээнд мөрдөж ажиллана. | 16538.1 |
| 4.5. | Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй үндэсний 10 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж сургалт сурталчилгааг зохион байгуулж ажиллана. | 2583.8 |
| 4.6. | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хуулийн дагуу үнэн зөв тайлагнаж Аудит,бусад хуулийн байгуулагаар хянуулж баталгаажуулан заавар журмыг мөрдөн ажиллана. | 205.1 |
| 4.7. | Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор гэрэл цахилгаан,бичиг хэрэг цэвэр ус,эд хогшил нормын хувцас урсгал засвар шуудан холбоо томилолт,урсгал засварын зардлыг хуулийн дагуу хангаж ажиллана. | 9989.7 |
| 4.8 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 5400,0 |
| **4.9** | **Нийт зардал** | **238040,2** |
| **5** | **Соёлын төв** | |

| | | |
|---|---|---|
| 5.1. | Соёлын төвийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангах | 30356.2 |
| 5.2. | Ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн тав тухтай нөхцөлийг хангах таатай орчныг бүрдүүлэх Үүнд: Соёлын төвийн гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны хангалт хэвийн байлгах нөхцөл бүрдэнэ. | 4091.9 |
| 5.3. | Соёлын төвийн орчны тохижилтыг сайжруулах, материаллаг баазыг хангах | 5,173.4 |
| | **Урлаг, спортын арга хэмжээг явуулах** | |
| 5.4. | Ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн дунд урлаг уран сайхан, спортын төрөл бүрийн арга хэмжээг удирдамжийн дагуу төлөвлөн зохион байгуулж чөлөөт цаг, тэмдэглэлт өдрүүдийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулах | 2110.0 |
| | **Нийгмийн баталгаагаар хангах үйл ажиллагаа** | |
| 5.5. | Боловсон хүчний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн сургалтанд хамруулах, тогтвор суурьшил болон нийгмийн бүхий л даатгалд хамруулан батлагаагаар хангах | 5881.0 |
| | **Төсвийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа** | |
| 5.6. | Төсвийн нээлттэй, тогтвортой үйл ажиллагааг хангаж хөндлөнгийн аудит хийлгэх Төсвийн үйл ажиллагааны ил тод байдал хангахад зориулах | 196.3 |
| **5.7.** | **Нийт зардал** | **47808.8** |
| **6** | **ЕБС-н үндсэн үйл ажиллагаа** | |
| 6.1 | ЕБС нь 1-9р ангийн хүүхдийн сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангах<br>Багш, ажилчдын ажлын чанар үр дүнг харгалзан урамшуулал олгох | 245,495.0 |
| 6.2 | Багш, ажилчдынхаа нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн бүхий л даатгалд хамруулах | 26,674.6 |
| | **Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах үйл ажиллагаа** | |
| 6.3 | Ажиллагсад болон суралцагчын ажиллаж, суралцах тав тухтай нөхцөлийг хангах таатай орчныг бүрдүүлэх Үүнд: Сургуулийн гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны хангалт хэвийн байлгах нөхцөл бүрдэнэ. | 13,137.0 |
| 6.4. | Сургалтын орчны тохижилт,засвар үйлчилгээ материаллаг баазаар хангаж орчин нөхцөл сайжруулах | 10,243.0 |
| | **Эрүүл аюулгүй хоол хүнсээр хангах үйл ажиллагаа** | |
| 6.7. | Дотуур байранд амьдарч буй сурагчдыг эрүүл аюулгүй хоол хүнсээр хангаж шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх | 15,444.0 |
| 6.8. | Бага ангийн сурагчдад эрүүл аюулгүй, чанарын шаардлагад нийцсэн хоол хүнсээр хангах | 8,882.0 |
| | **Нийгмийн баталгаагаар хангах үйл ажиллагаа** | |
| 6.9. | Боловсон хүчний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн сургалтанд хамруулах, бүтээлээ бусдын хүртээл болгоход зориулах ном бичиг хэрэгслийн материалаар хангах | 1,716.0 |
| 6.10. | Боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах болон тэтгэвэрт гарахад нь тусламж дэмжлэг үзүүлэх | 26,788.3 |

| | | |
|---|---|---|
| | **Төсвийн нээлттэй ил тод байдлыг хангах үйл ажиллагаа** | |
| 6.11 | Төсвийн нээлттэй, ил тод, тогтвортой үйл ажиллагааг хангаж хөндлөнгийн аудит хийлгэх | **586.0** |
| **6.12.** | **Нийт зардал** | **348,965.9** |
| 7 | **Сургуулийн өмнөх боловсролын үндсэн үйл ажиллагаа** | |
| 7.1 | Сургуулийн өмнөх 2-5 насны хүүхдийн тойргийн хамран сургалтыг 80-с дээш хувьд хүргэх<br>Үүнээс: **ердийн** бүлгийн хамралтыг 50 хувьд, **хувилбарт** сургалтын хамралтыг 30 хувьд тус тус хүргэж хамран сургалтын хувийг аймгийн дунджаас дээгүүр хувьд хүргэн, өмнөх оноос 2-3 хувиар ахиулна. | **96,544.3** |
| 7.2 | Цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, дулаанаар найдвартай хангаж хүүхдийн сурч хөгжих аятай тухтай орчинг бүрдүүлнэ. | **10,841.5** |
| 7.3 | Багш ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн сургалтанд хамруулах, ном бичиг хэрэгсэлийн материалаар хангаж, үр дүнг тооцно. | **3,109.1** |
| 7.4 | МХТехнологийг нэвтрүүлж цахим сургалтыг сургалтандаа ашиглаж хэрэглээ болгоно. | **781.5** |
| 7.5 | БНХүүхдэд ариун цэвэр эрүүл ахуйн дадал хэвшил эзэмшүүлж эрүүл аюулгүй орчинд сургаж хөгжүүлнэ. | **5,851.8** |
| 7.6 | Хүүхэд эцэг эх багш ажилчдын дунд урлаг уран сайхан, спортын төрөл бүрийн уралдаант арга хэмжээг удирдамжийн дагуу төлөвлөн зохион байгуулж, чөлөөт цаг, тэмдэглэлт өдрүүдийг зөв боловсон өнгөрүүлэн авьяасыг нээн илрүүлнэ. | **50.5** |
| 7.7. | Дүн | *117,178.7* |
| | **Нийгмийн баталгаагаар хангах үйл ажиллагаа** | |
| 7.8. | Багш ажиллагсдыг нийгмийн бүхий л даатгалд хамруулан нийгмийн асуудлыг нь дотоод журамдаа заасны дагуу шийдвэрлэх ба ажилдаа хандах бүтээлч хандлагыг нэмэгдүүлэн сэтгэл зүйн эерэг уур амьсгал бүрдүүлнэ. | **18,958.8** |
| | Дүн | *18,958.8* |
| | **БНХүүхдийг хоол хүнсээр хангах үйл ажиллагаа** | |
| 7.9. | Эрүүл аюулгүй чанартай илчлэг калоритой хоол хүнсээр хангаж 2-5 настай хүүхдэд ногдох амин дэмийг бүрэн өгч эрүүл чийрэг бие бялдартай иргэн болгон төлөвшүүлнэ. | **10,557.9** |
| 7.10. | **Дүн** | *10,557.9* |
| **7.11.** | **Нийт зардал** | **146,695.4** |

ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
5 дугаар хуралдааны 19 дугаар тогтоолын
2 дугаар хавсралт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд хийгдэх
хөрөнгө оруулалт хөтөлбөр, төсөл арга
хэмжээний жагсаалт

| № | Төсөл арга хэмжээний нэр,хүчин чадал, байршил | Дугаар | Эхлэх дуусах хугацаа | Төсөвт өртөг мян/төг | 2017 онд санхүүжих дүн1 |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2016 онд хийгдээгүй хөрөнгө оруулалтаас | | | | |
| 1.1 | Нэг цэгийн үйлчилгээ иргэний танхимын халаалтын системийг солих,засьарлах, тоног төхөөрөмж худалдан авах | 1 | 2017 | 23.400.0 | 23.400.0 |
| 2 | 2017 онд шинээр хийх хөрөнгө оруулалт | | | | |
| 2.1 | Сумын ерөнхий хөгжлийн төлөвлөгөө | 2 | 2017 | 29.400.0 | 15.304.2 |
| 2.2 | Цахим аймаг хөтөлбөр/видео хурлын тоног төхөөрөмж / | 3 | 2017 | 9218.0 | 9218.0 |
| 2.3 | Сумын баяр наадмын зардал | 4 | 2017 | 5.000.0 | 5.000.0 |
| 2.4 | Сумын төвийн халуун ус засварлах | 5 | 2017 | 10.000.0 | 10.000.0 |
| 2.5 | Цагдаагийн бэлэн бус торгуулийн тоног төхөөрөмж | 6 | 2017 | 2.498.6 | 2.498.6 |
| 2.6 | Биохимийн аппарат | 7 | 2017 | 17.000.0 | 17.000.0 |
| | **ОНХСангаас санхүүжих нийт дүн** | | | | **82.420.8** |

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2017 оны 11 сарын 22 ны өдрийн 19 -р тогтоолын 3 дугаар хавсралт

## Сангуудын орлого зарлагын тооцоо

**Сум хөгжүүлэх сан**

мян/төгрөг

| № | Тайлбар | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага |
|---|---|---|---|---|
| 1 | Иргэдийн зээлийн эргэн төлөлтийн орлого | | 56606.9 | |
| 2 | 2016 оны дутуу төлөлт | | 11486.3 | |
| 3 | Буцаан олгох зээл | | | 58500.0 |
| 4 | Бичиг хэргийн зардал | | | 1500.0 |
| 5 | Оны үлдэгдэл | 14725.0 | | |
| 6 | | | | |
| 7 | **Дүн** | **14725.0** | **68093.2** | **60000** |

**Мал хамгаалах сан/ мян төгрөг/**

| № | Тайлбар | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага |
|---|---|---|---|---|
| 1 | Орон нутгийн хөгжлийн сангаас | | 0.0 | |
| 2 | Иргэдээс авах авлага | | 5.7 | |
| 3 | Аж ахуйн төлөх тооцоо | | 1800.0 | |
| | зарагдах өвснөөс орох | | 5682.0 | |
| | Өвс тэжээл авахад | | | 18175.6 |
| | Оны үлдэгдэл | 10687.9 | | |
| | **Дүн** | **10687.9** | **7487.7** | **18175.6** |

**Байгаль хамгаалах сан /мян төгрөг/**

| № | Тайлбар | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага |
|---|---|---|---|---|
| 1 | Байгаль хамгаалах нөхөн сэргээх оны үлдэгдлээс | | | **1430.0** |
| 2 | Мод усалгаа оны үлдэгдлээс | | | **1000.0** |
| 3 | Нохой устгах / оны үлдэгдлээс | | | **300.0** |
| 4 | Нөхөн сэргээлтийн оны үлдэгдлээс | 7179.9 | | |
| 5 | Жоншны тээвэрлэлт хийсэн ком-с орох | | | |
| 6 | Хайгуулын зөвшөөрөлтэй компани үйл ажиллагаа явуулбал | | 1322.0 | |
| | | **7179.9** | **1322.0** | **2730.0** |

**Ахмадын сан**

| № | Сангууд | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага |
|---|---|---|---|---|
| 1 | ЗДТГ-ын ахмад | 3587.4 | 1240.0 | 998.0 |
| 2 | ИТХ-ын ахмад | 152.6 | 410.6 | 250.0 |
| 3 | ЭМТ-ийн ахмад | 1222.5 | 3000.0 | 1024.1 |
| 4 | ЕБС-ийн ахмад | 483.7 | 1881.0 | 1025.0 |
| 5 | СӨБ-ийн ахмад | 575.9 | 2900.0 | 1031.9 |
| 6 | Соёлын төвийн ахмад | 27.2 | 566.0 | 531.0 |
| 7 | | **6049.3** | **9997.6** | **4860.0** |

ДУНДГОВЬ АЙМАГ
ЛУУС СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 11 сарын 22 өдөр Дугаар 21 Цагаан-Овоо

Орон нутгийн тусгай хамгаалалтанд
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "к", Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дах заалтуудыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дундговь аймгийн Луус сумын нутагт орших нэр бүхий 13 газрыг 40 жилийн хугацаатай орон нутгийн тусгай хамгаалалтад авсугай.

2.Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газруудын нэр, солбицол, үндэслэл, байршлыг нэг дүгээр хавсралтаар, тусгай хамгаалалттай газрын зураглалыг хоёр дугаар хавсралтаар тус тус батлсугай.

3.Тогтоолыг холбогдох газарт нь хүргүүлэн бүртгүүлж, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга /Л.Цогзолмаа /-д үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2017 оны 06 сарын 07-ны өдрийн 13 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын ХААБО /Б.Жаргалням /- д даалгасугай.

ДАРГА Д.ЭНХБААТАР

/Togtool 2017/ doc

Сумын ИТХ-ын 2017 оны 11 сарын 22-ны
21 тоот 2 тоот тогтоолын
1дүгээр хавсралт

ЛУУС СУМЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВАХ ГАЗАР

| № | Хамгаалалтад авах газрын нэр | Харъяалах баг талбайн хэмжээ /га/ | Талбайн булангийн цэгийн солбицол /координат / | Хамгаалалтад авсан үндэслэл | Газрын байршил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Суварга хайрхан | Суварга 400.0 | 105$^0$34'41.24" 45$^0$37'31.61"<br>105$^0$32'51.24" 45$^0$37'31.61"<br>105$^0$32'51.24" 45$^0$38'21.6"<br>105$^0$34'41.24" 45$^0$38'21.6" | Түүх сёлын дурсгалт газар | Сумын төвөөс баруун БХ 22км<br>Майхан уулаас БУ 5км<br>Элсний овооноос ЗУ 5км<br>Дэлгэрэхийн уснаас ЗХ 8км |
| 2 | Салхит хайрхан | Суварга 200.0 | 105$^0$27'58.26" 45$^0$47'41.63"<br>105$^0$28'13.73" 45$^0$48'2.27"<br>105$^0$28'46.23" 45$^0$48'17.05"<br>105$^0$28'46.19" 45$^0$47'41.59" | Түүх, соелын дурсгалт газар | Бухатын нуурнаас БУ 3 км<br>1-р баг 1336.7 тоот өндөрлөгөөс Х -3км |
| 3 | Олгойн шавар | Суварга 0,5 | 105$^0$49'19.27" 45$^0$54'23.6"<br>105$^0$49'9.29" 45$^0$54'11.6"<br>105$^0$49'6.29" 45$^0$54'23.6"<br>105$^0$49'12.28" 45$^0$54'30.6" | Байгалийн нөөц газар | Сариг хайрханаас урагш 2км<br>Элэгний рашаанаас зүүн тийш 2км |
| 4 | Сариг хайрхан, элэгний рашаан | Буянт 600.0 | 105$^0$49'12.41" 45$^0$56'3.70"<br>105$^0$46'31.26" 45$^0$54'31.63"<br>105$^0$45'11.3" 45$^0$55'51.6"<br>105$^0$48'54.90" 45$^0$56'20.53" | Түүх соёлын дурсгалт газар | Шар дэрснээс ЗХ 5км<br>Олгойн худгаас БХ 10км<br>Өнгөтөөс З 7км<br>Дарцагтаас ЗУ 5км |
| 5 | Завгийн цагаан чулуу, булаг | Суварга 300.0 | 105$^0$43'34.8" 45$^0$38'09.3"<br>105$^0$42'55.3" 45$^0$38'44.9"<br>105$^0$43'56.3" 45$^0$39'12.4"<br>105$^0$44'35.9" 45$^0$38'28.1" | Түүх соёлын дурсгалт газар | Завгийн нуураас У 4км<br>Хөх толгойгоос ЗХ 3км<br>Завгийн хяраас Б 4км<br>Хөх овоон сүүжээс Х 8км |
| 6 | Толийн булаг | Наран 2.0 | 105$^0$57'1.29" 45$^0$17'38.55"<br>105$^0$56'37.28" 45$^0$17'26.55"<br>105$^0$56'29.28" 45$^0$17'32.55"<br>105$^0$56'50.29" 45$^0$17'58.55" | Байгалийн нөөц газар, Булаг шандны эхийг хамгаалах зорилгоор | Шувуутайн уулаас Х 15км<br>Гуяын хяраас З 10км<br>Нүдэнгийн хөхөөс Б 7км<br>Хар овооноос У 16км |

Сумын ИТХ-ын 2017 оны 11 сарын 22-ны
21 тоот 2 тоот тогтоолын
1дүгээр хавсралт

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Наран булаг | Наран 5.0 | 105⁰50'4.3" 45⁰23'49.55"<br>105⁰55'21.29" 45⁰23'33.55"<br>105⁰50'37.3" 45⁰23'12.55"<br>105⁰49'59.3" 45⁰23'33.55" | Байгалийн нөөц газар, Булаг шандны эхийг хамгаалах зорилгоор | Сумын төвөөс У 14км<br>Могойтоос Б 4км<br>Хар овооноос Х 7км<br>Босгын бууцнаас З 7км |
| 8 | Хөшөө хонгор | Наран 0.5 | 105⁰59'3.22" 45⁰35'31.62"<br>105⁰59'2.22" 45⁰35'31.62"<br>105⁰59'3.22" 45⁰35'32.62"<br>105⁰59'4.22" 45⁰35'32.62" | Түүх соёлын дурсгалт өвөрмөц тогтоцтой газар | Баян хараас З 5км<br>Булаг шанднаас Х 3км<br>Шинэ уснаас Б 9км<br>Баянгийн худгаас Х 13км |
| 9 | Үнэгт хайрхан | Наран 100.0 | 105⁰58 36.31" 45⁰25'51.54"<br>105⁰58'36.31" 45⁰25'11.54"<br>105⁰57'41.31" 45⁰25'11.54"<br>105⁰57 41.31" 45⁰25'51.55" | Түүх соёлын дурсгалт газар | Толийн булагаас Х 20км<br>Могойтоос З 7км<br>Зээгийн хэцээс У 8км<br>Цахирын хэцээс Б 14км |
| 10 | Алтан хайрхан | Наран 100.0 | 106⁰06'51.38" 45⁰28'1.57"<br>106⁰06'51.38" 45⁰27'31.57"<br>106⁰05'51.38" 45⁰27'31.57"<br>106⁰05'51.38" 45⁰28'1.57" | Түүх соёлын дурсгалт газар | Бурханаас У 5км<br>Дулаан хайрханаас З 4км<br>Хүрэн хаднаас БХ 5км<br>Өндөр зэлээс Б 3км |
| 11 | Их хатуугийн уул | Наран 750.0 | 105⁰42'54.7" 45⁰25'29.3"<br>105⁰44'43.4" 45⁰29'13.8"<br>105⁰42'07.6" 45⁰28'21.6"<br>105⁰41'00.7" 45⁰25'58.5" | Түүх соёлын дурсгалт газар | Сумын төвөөс БУ 5-10км<br>Цагаан овоогоос Б 3км<br>Төгрөгийн хужираас З 3км |
| 12 | Төгрөгийн хужир | Наран 5.0 | 105⁰39'57.4" 45⁰26'50.3"<br>105⁰40'13.4" 45⁰26'16.9"<br>105⁰39'05.6" 45⁰26'20.6"<br>105⁰39'06.3" 45⁰26'54" | Байгалийн нөөц газар | Сумын төвөөс БУ 13км<br>Хатуугийн уулнаас Б 3км |
| 13 | Гурван шовх Сахалын булаг | Наран 2160 | 105⁰59'52.9" 45⁰27'13.2"<br>106⁰03'00.8" 45⁰28'11.1"<br>106⁰04'24.6" 45⁰26'19.8"<br>106⁰00'49.9" 45⁰25'09.4" | Түүх соёлын дурсгалт газар, булаг шандны эхийг хамгаалах зорилгоор | Сумын төвөөс ЗУ 15 км<br>Алтан хайрханаас У 4 км<br>Хүрэн хадын голоос З 5км<br>Үнэгт хайрханаас З 2,5 км |

Сумын ИТХ-ын 2017 оны 11 сарын 22-ны
өдрийн 21 тоот тогтоолын
2 дугаар хавсралт

Дундговь аймгийн Луус сумын нутагт орших тусгай хамгаалалттай газрын хилийг харуулсан зураг




Таних Тэмдэг

Зургийн масштаб 1:365.000

Луус сумын хил

нөөцөд авсан газар

хүчинтэй байгаа лицэнзүүд

Тусгай хамгаалалттай газар ба түүний байршил, хил